

Иймд нүүдэлчин монголчууд Хятад улсыг захирахдаа арга буюу хятадын уламжлалыг зээлдэн авч цаашид хөгжүүлэхэд хүрсэн ажээ. Энэ бүхнээс үзэхэд нүүдэлчин суурьшмал улс үндэстнүүдийн соёл, улс төрийн нөлөөлөл, түүний мөн чанар, цар хүрээ эдгээр иргэншлийн онцлог, шинж чанараар тодорхойлогдож байжээ.

Ийнхүү нүүдлийн мал аж ахуйн болон газар тариалангийн аж ахуйн хэвшил нь хоёр иргэншлийг зааглах хүчин зүйл нь болж байжээ. Чингэхдээ энэхүү хоёр иргэншил нь бие биенээсээ огт тасархай байгаагүй бөгөөд харилцан бие биендээ үйлчилж зохих хэмжээгээр нөлөөлсөөр иржээ.

### **БНМАУ ДАХЬ ХЯТАД СУДЛАЛ, ЦААШДЫН ЗОРИЛТ**

**Н. Алтанцэцэг\***

Хөрш зэргэлдээ орших Хятад орныг судалж мэдэх явдал энэ орны баялаг түүх, өвөр мөц соёл иргэншил, тухайн орны орчин үеийн дотоод, амьдрал, гадаад бодлогыг танин мэдэхэд ач холбогдолтой нь зүйн хэрэг.

Манай орны хувьд авч үзэхэд амьдралын өвөрмөц хэлбэр, нийгмийн өөр өөр байгуулалттай хоёр орон өнө удаан жил зэрэгцэн тогтнохдоо улс төр, эдийн засаг, нийгмийн эрх ашгийн үүднээс түүхийн тодорхой үе шатуудад янз бүрийн харилцаатай байсан. Түүгээр ч үл барам хоёр орон нэг биш удаа их гүрний хүрээнд багтан оршиж байсан ч удаатай.

Монголчууд төр улсаа төвхнүүлэн өнө удаан жил оршин тогтнохдоо өмнөд хөрш Хятад улстай харилцаж ирсэн төрийн уламжлалт бодлого баримталж байсан. Монголын хаад ноёд, төрийн түшмэдүүд эрт дээр үеэс Хятадын төрийн бодлого, зан үйлийг сайтар мэдэж, түүний үндсэн дээр Хятадтай харилцах бодлого явуулж байсан нь Монголын хятад судлал урт удаан жилийн уламжлалтайг гэрчилж байгаа юм.

Энэхүү өгүүлэлд БНМАУ байгуулагдсанаас хойшхи Монголын түүхчид, хятад судлаачдын туурвисан бүтээлүүдийг нэгтгэн базаж, түүний үндсэн дээр судалгааны чиглэлүүдийг гаргаж, цаашдын судалгааны зорилтыг тодорхойлох оролдлого хийлээ. Харин эдгээр бүтээлүүдэд үнэлэлт дүгнэлт хийхийг зорьсонгүй.

1921 оны ардын хувьсгал ялж улмаар БНМАУ-ыг тунхагласан цагаас хойш 1949 оныг хүртэлх Монголын хятад судлал, өөрөөр хэлбэл Хятадаас Монголын талаар баримталж байсан бодлого, монгол-хятадын харилгааны ээдрээтэй асуудлуудыг судлан нийтэлж өргөн олны хүртээл болгох ажил хийгдэж байсангүй. Энэ нь нэг талаас Хятад нь Монгол улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхгүй байсан, нөгөө талаас БНМАУ-д эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага байгуулагдан хөл дээрээ зогсож амжаагүй байсан ба хятад судлалын мэргэжлийн хүмүүс дутмаг байсантай холбоотой.

Харин Хятадын тухай мэдээ, баримтууд, Хятадаас Монголын талаар явуулж байсан бодлого, хоёр орны харилцааны асуудлуудтай холбогдох материалууд төрийн хэмжээнд боловсрогдон архивт хадгалагдаж байснаас судалгааны эргэлтэнд оруулж хэвлэх ажил төдийлөн хийгдээгүй байсан байна.

1949 онд Хятадад ардын хувьсгал ялж социалист замаар хөгжих болсон үеэс хоёр орны харилцаа сайжирч Хятадыг сонирхон сурталчлах ажил хийгдэж эхэлсэн билээ. Хятад оронд ардын хувьсгал ялснаас

хойш 60-аад оны дунд үеийг хүртэл гол төлөв марксизм-ленинизм түгэн дэлгэрч хэрэгжсэн, социалист бүтээн байгуулалтын ололт амжилтыг, Хятадын Коммунист намын удирдан чиглүүлэх үүргийг сурталчлан таниулах ажлыг хийж байжээ. Үүний зэрэгцээгээр Хятадын уран зохиол, үлгэр .. зэргийг орчуулж ард түмэнд таниулах ажил зохиогдож байжээ. Энэ үед Монголын түүхчид манжийн эсрэг монголын ард түмний тусгаар тогтнолын төлөө тэмцэл, Монгол ван тайж нарын намтар, Богд хаант Монгол улсын үеийн монголын гадаад бодлого, монгол-хятадын харилцаа, мөн манжийн үеийн монголын түүхийн асуудлууд, өөрөөр хэлбэл манжийн захиргаанд байсан монголчуудаас манжийн төрд төлж байсан алба гувчуур, тэр үеийн Ар Монголын засаг захиргааны зохион байгуулалт, Ар Монголсос Манж Чин улсад залгуулж байсан алба, Хятадын мөнгө хүүлэгч худалдаа Монголд нэвтэрсэн ту хай судалж бичсэн эрдэм шинжилгээний дорвитой бүтээлүүдийг туурвижээ. Гэвч эдгээр нь гол төлөв Хятадтай холбогдох Монголын түүхийн судалгааны бүтээлүүд юм.

БНМАУ-д Хятадыг судлах ажил 1960-аад оны сүүлээс эрчимтэй явагдаж ирлээ. 1968 онд ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын дэргэд Ази, Африкийн хэлтэс анх 7 хүнтэй байгуулагдсан явдал Ази, Африкийн орнууд, тухайлбал Хятадыг судлах ажлыг эрдэм шинжилгээний чиглэлтэй болгоход чухал алхам болсон юм. Эдүгээ энэ хэлтэс, өргөжсөөр ШУА-ийн Дорнодахин, олон улс судлалын хүрээлэн болж хятад судлалын ажлыг эрхлэн явуулж байна. Энэ хугацаанд хятадын асуудлаар болон Хятадтай холбогдох Монголын түүхийн асуудлаар дэд эрдэмтний зэрэг 12 хүн, докторын зэрэг 2 хүн хамгаалсан байна. Мөн хугацаанд хятадын талаар 20 гаруй эрдэм шинжилгээний ном, товхимол, өгүүллийн эмхтгэл гаргажээ. 1978 оноос тус хүрээлэн «Дорнодахины судлалын асуудал» сэтгүүл эрхлэн гаргах болсон нь хятадын талаар хийсэн судалгааг уншигч олонд таниулах өргөн боломжтой болсон юм. Уг сэтгүүл 1978 оноос 1980 онд жилд нэг удаа гардаг байсан бол 1981 оноос жилд 2 удаа гардаг болж, 1991 оноос жилд 4 удаа гардаг болоод байна.

Өнгөрсөн хугацаанд Монголын түүхчид, хятад судлаачдын туурвисан бүтээл, хамгаалсан диссертациудыг судалгааны чиглэлээр нь авч үзвэл:

Нэг. Хятадтай холбогдох Монголын түүхийн судалгааны бүтээлүүд. Үүнд: Монгол, Хятад хоёр орон нэг гүрний дотор зэрэгцэн оршиж байсан Юань, Чин улсын үеийн Монголын түүх, тухайн үеийн Монгол-Хятадын харилцааны түүх, Хятадаас Монголд явуулж байсан бодлого, Монголын ард түмний тусгаар тогтнол, эрх чөлөөний төлөө тэмцлийн асуудлууд орж байна.

Хоёр. Хятад дахь Монголчуудын түүхийн сурвалж бичиг, монголын түүх судлалын асуудлаар туурвисан бүтээлүүд. XIII зууны үеийн монголчуудын түүх, угсаатны зүйн эх сурвалж болох Өмнөд Сүн улсын дипломатуудын тэмдэглэл, мөн БНХАУ-д монголын түүхийг судалж буй талаар хийсэн судалгаанууд орж байна.

Гурав. Хятадын гадаад бодлого, монгол-хятадын харилцааны талаар туурвисан бүтээлүүд. Монголын гадаад харилцааны түүхэнд Монгол-Хятадын харилцааны түүх тодорхой байр эзэлдэг. Энэ хугацаанд монголын улс төрийн гадаад бодлогын эрт, эдүгээгийн түүхийн асуудал, Хятадаас гадаад орнуудад явуулж байсан бодлого, Монгол-Зөвлөлт-Хятадын харилцааны асуудал, 1949 оноос 1984 он хүртэлх Монгол-Хятадын харилцаа, их гүрнүүдээс Богд хаант Монгол улсын талаар явуулж байсан бодлого, Хятадаас БНМАУ-ын талаар явуулж бай-

сан суртал ухуулга, мөн Монгол-Зөвлөлтийн найрамдлын харилцааг таслах гэсэн маоист удирдлагын бодлого зэрэг асуудлаар судалгаа хийсэн байна.

Дөрөв. Дээрх хугацаанд хийсэн судалгааны нэг гол чиглэл бол Хятадын өөртөө засах үндэсний районуудын түүх, соёл, нийгэм, эдийн засгийн байдлыг судалсан явдал юм. Үүнд: XIX зууны II хагас, XX зууны Өвөр Монгол, 1976—1983 оны үндэсний өөртөө засах зарим орны байдал, БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орон, ӨМӨЗО-ы зарим үндэстэн ястны гарал үүслийн тухай, «Соёлын хувьсгал»-ын үеийн ӨМӨЗО-ы байдал, 1976—1984 онд хятадын удирдлагаас Өвөр Монголд явуулж байсан бодлого, маогийн бодлогод хэлмэгдэж буй Төвд орон, 1970—80-аад оны Синьзян-Уйгурын ӨЗО-ы уугуул ард түмнүүдийн үндэсний соёлын бүтээн байгуулалт, мөн Өвөр Монголын ардын аман зохиол, түүнд тусгагдсан эрх чөлөөний тэмцэл болон Өвөр Монголын хэл бичгийн дурсгал зэрэг судалгаануудыг хийсэн байна.

Тав. МАХН-аас Хятадын талаар баримталж байсан бодлого, МАХН ың үзэл суртлын тэмцлийг харуулсан бүтээлүүд хэвлэгдэн гарчээ. МАХН-аас Монгол-Хятадын харилцааны талаар баримталж байсан байр суурь, тухайн үеийн Хятадын удирдлагын бодлогыг шүүмжилж, тэмцэж байсан арга замуудыг тусган харуулжээ.

Өнгөрсөн жилүүдэд хийсэн судалгаа шинжилгээний болон хятадын талаар хэвлэгдсэн ном зохиолуудыг авч үзэхэд дээрх 5 төрөлд ангилан үзэж болох мэт санагдана.

Хэдийгээр БНМАУ дахь хятад судлал үүсч хөгжөөд 20 гаруй жил болж байгаа боловч энэ хугацаанд судалгаа, эрдэм шинжилгээний чанартай багагүй бүтээлүүдийг туурвисан байна. Гэвч 1960-аад оны эхнээс хоёр орны харилцаа муудаж ирсэн явдал шинжилгээ, судалгааны ажилд ч сөрөг нөлөө үзүүлсэн нь судалгааны бүтээлүүдээс тодорхой байна. 1960-аад оноос хятадын судалгааны ажил хятадын гадаад, дотоод бодлогыг буруушаан шүүмжлэх хандлагыг баримталж байсан. Ялангуяа маоизмтэй тэмцэх уриан дор судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг улс төр, үзэл сурталд автагдуулж, ийм өнгө аястай ном, өгүүллийн эмхтгэл, товхимлуудыг багагүй хэвлэн гаргаж байсныг энд хэлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Аливаа асуудлыг судлахдаа тодорхой чиг хандлагад тохируулсан нам, төрийн бодлогыг зөвтгөх үүднээс судалгаа явуулдаг байсныг ч нуух хэрэггүй биз ээ. Ганцхан зүйлийг жишээ болгон энд өгүүлье. БНХАУ нийт социалист гэгдэж байсан орнуудын баримталж байсан нийтлэг социализм Хятадад тохирохгүй гэдгийг бүр 1950 оны сүүлчээс мэдэрч «өөрийн хүчинд тулгуурлан» онцгой чиг шугам баримтлах, сүүлдээ «хятадын онцлогтой социализм» байгуулна гэж удаа дараа тунхаглаж байсан. Тэгээд ч 1978 оноос эхлээд өөрчлөн байгуулалт хийхээ зарлан эдүгээ шинэчлэлийн замаар замнаж байна. 1958—1980 оны хооронд хятадын эдийн засагт учирч байсан бэрхшээл түүнээс гарах гэсэн хятадын удирдлагын янз бүрийн оролдлогыг бид шүүмжилж байсан болохоос тухайн үеийн нийгэм-эдийн засгийн байдалд бодит үнэлгээ дүгнэлт өгөхөөсөө муулан буруушаах хандлагыг барьж байсан. Өнөөдрийн манай эдийн засгийн хүнд байдал, түүнээс гарах арга замыг эрэн хайж байгаа нь 70-аад оны сүүл 80-аад оны эхний Хятадын эдийн засгийн байдал, түүнээс гарах гэсэн арга замуудтай нийтлэг ижил төстэй байна. Жишээ нь, жижиг үйлдвэр байгуулах, хувийн худалдаа хөгжүүлэх, хувь нийлүүлсэн компани байгуулах, гадаад хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөгжингүй капиталист орнуудтай худалдаа, эдийн засгийн холбоо тогтоох арга замуудыг эрэлхийлэн хэрэгжүүлж байсан явдал юм. Гэтэл манай хятад судлаачдын 80-аад оны

эхний бүтээлүүдэд тухайн үеийн хятадын нийгэм-эдийн засаг, гадаад харилцааны асуудлуудыг судлахдаа «БНХАУ социалист хамтын нөхөрлөлийн орнуудаас салан хөндийрч империализм харгислалын хүчинтэй сүлбэлдэж, Хятад орны социалист бүтээн байгуулалтын үйл хэргийг тасалдуулж байна» гэх мэтийн дүгнэлт өгч байсан нь Хятадыг судлах судалгаанд улс төр, үзэл сурталчлал зонхилж байсныг гэрчилж байна.

Хятад-Монголын харилцаа хурцадмал байсан 30-аад жилийн хугацаанд манай талаар БНХАУ-д хэвлэгдэж байсан ном, хэвлэлүүд ч мөн үзэл суртал, улс төрийн бодлогод автагдсан байсныг бид үгүйсгэхгүй.

Өнөөдөр хүн төрөлхтөн аливаа асуудлаар харилцан дайсагналцах биш хэл амаа ололцон ойлголцохыг эрмэлзэх болсон шинэ нөхцөл бүрдээд байна. Энэ нөхцөлд манай улс хөрш хоёр оронтойгоо найрамдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх, улс орны дотоод хэрэгт үл оролцох, энх тайвнаар зэрэгцэн орших зарчим баримтлан улс төр, эдийн засагт харилцан ашигтай бодлого явуулах нь манай ард түмний эрх ашигт нийцэх нь зүйн хэрэг.

Судалгааны бүтээлүүдээс үзэхэд 1986 оноос хойш Хятадын асуудлуудад хандах хандлаганд эргэлт гарч үзэл суртлаас ангижрах байдал ажиглагдаж ирлээ. Өмнө судалж байсан судалгааны уламжлалт чиглэл болох Юань, Манжийн үеийн Монголын түүх, Монгол-Хятадын харилцаа зэрэг асуудлуудаас гадна Хятадын түүхийн зангилаа асуудлууд, орчин үеийн Хятадын нийгэм-эдийн засаг, ялангуяа хятадын шинэчлэлийн асуудлууд, тэдгээр нь Хятадын өөртөө засах орнуудад хэрхэн явагдаж байгаа, орчин үеийн Монгол-Хятадын харилцаа, Хятадын гадаад бодлого, хятад болон хятад биш үндэстнүүдийн түүх, соёл, зан заншлыг судлахад анхаарлаа хандуулж ирлээ.

Онцлон хэлэхэд манай улстай нийгэм, эдийн засаг, үзэл суртлын ижил системтэй байсан БНХАУ-д хийгдэж буй нийгэм-эдийн засгийн шинэчлэл, түүнийг хийсэн арга замууд, мөн манайхтай төстэй цаг агаар, ижил аж ахуйг эрхэлдэг ӨЗО-уудад эдийн засгийн шинэчлэл хэрхэн явагдаж байгаа асуудал өнөөдөр манай хятад судлаачдын анхаарлыг татсаар байна.

Монгол-Хятадын харилцаа сайжирч, өргөжиж байгаа өнөө үед Хятад орны бодит байдлыг нүдээр үзэж, танилцах боломж бий болсон нь Хятад орны амьдралыг үнэн бодитойгоор танин мэдэхэд ихээхэн ач холбогдлоо өгч байгааг цохон тэмдэглүүштэй.

Манай оронд болж байгаа өөрчлөлт шинэчлэлтийн үр дүнд оюуны хүлээс тайлагдаж аливаа судалгааг онол, үзэл сурталд автагдуулдаг байсан хуучин арга барилаас ангижирч байгаа өнөө үед хятад судлал, судалгааны ажилд зохих өөрчлөлт гаргах нь зүйтэй гэж үзэж байна.

Нэг. Хятад орон өнө эртний баялаг түүхтэй. Өөрийн өвөрмөц түүх, соёлоороо дэлхийн соёл иргэншлийн санд тодорхой байр суурь эзэлдэг. Гэтэл манай судлаачдын бүтээлүүдэд энэхүү хэдэн мянган жилийн баялаг түүхээс гол төлөв хувьсгалт тэмцлийн түүх, ХКН-ын түүхийн зарим асуудлууд, хувьсгалчдын үйл ажиллагаа зонхилох байрыг эзэлж байна. Хятадын түүхийг судлахдаа өргөн цар хүрээтэй түүхэнд тодорхой ул мөр үлдээсэн үйл явдлуудыг бодитойгоор бичиж, Хятадын түүхийн судалгааны хүрээг өргөжүүлэх нь зүйтэй.

Хоёр. Орчин үеийн Хятадыг судлахдаа улс орны нийгэм эдийн засгийн байдал, гадаад харилцааг хамран судлах нь зүйн хэрэг. Улс орон мэдэгдэхүйц хурдтай хөгжиж байгаа өнөө үед судалгааны чиглэлийг аль болох уян хатан, цаг үеийн шаардлагын дагуу өөрчилж, судалгааг тухайн үеийн тулгамдсан шаардлагатай асуудлуудад чиглүүлж, шуурхай хийж байх нь чухал. Зах зээлд шилжиж байгаа манай орны хувьд

хятадын эдийн засгийн шинэтгэл, амжилтанд хүрсэн арга замууд, тулгарч байгаа бэрхшээлүүд зэргийг судлах нь өнөөдрийн цаг үеийн шаардлагатай нийцэж байна.

Гурав. Монгол-Хятадын харилцааны өнгөрсөн үеийн түүхийн асуудлуудыг судлахдаа гол, төлөв Хятадаас Монголын талаар явуулж байсан бодлогод анхаарлаа хандуулж бичиж байсан. Харин Монголын эзэн хаад, төрийн түшмэдүүдээс Хятадын бодлогыг хэрхэн мэдэж, байсан Хятадтай харилцаж байсан дипломат арга барилыг нь архивын материал, үг хэллэгт нь тулгуурлан цогцолбороор судлан гаргах нь чухал. Монгол-Хятадын Өнгөрсөн үеийн түүхийн харилцаатай холбогдох архивын материалуудыг судалгаа шинжилгээний эргэлтэнд оруулж судлан бичих нь зөвхөн эрдэм шинжилгээ, судалгааны төдийгүй энэ том хөрштэй өнө удаан жил харилцаж ирсэн гадаад бодлогын монгол уламжлалыг судлан гаргахад ач холбогдолтой.

Дөрөв. Монгол-Хятадын орчин үеийн харилцааг судлах ажил хэзээд хийгдэж байх ёстой. Монгол-Хятадын харилцаа хэвийн болж шинэ түвшинд гарсан өнөө үед хоёр орны харилцаа улс төр, эдийн засаг, соёл, шинжлэх ухааны бүх салбарыг хамарч байна. Хоёр орны харилцаа өргөжиж байгаа байдал, явц, эдийн засаг, худалдааны харилцаанд тулгарч байгаа бэрхшээлүүд зэргийг нэгтгэн дүгнэсэн цогцолбор судалгаа явуулах нь нэн шаардлагатай байна. Яам, тусгай газруудад байгаа хоёр орны харилцаанд холбогдох материалуудыг судалгааны эргэлтэнд (оруулж, түүний үндсэн дээр зохих дүгнэлт хийж, ирээдүйн төлөвийг тодорхойлж байх шаардлагатай байна.

Орчин үеийн хятад судлалын цар хүрээ, чиглэл, зорилтыг БНХАУ-тай харилцах чиг бодлогыг боловсруулан чиглүүлэхэд хувь нэмэр, үр өгөөжөө өгөхүйц хэмжээнд уялдуулан зохицууж, мэдлэг чадвар, дадлага туршлагатай мэргэжилтнүүдийг системтэй бэлтгэх явдал монголын хятад судлалын өнөөгийн нэн чухал зорилт болж байна.